



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnu.govi@audit.gov.mn

2024.08.06 № 533
танай _____ -ны № _____ -т

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРООНД

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох "Ардчилсан нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр (№... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Ардчилсан нам”-д



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ӨСӨХБАЯР

ӨМНӨГОВЬ
НУТГИЙН
ХИШИГ
2028

ИРГЭН БҮРИЙГ ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ, ЭХ
ОРОНТОЙ, ЭРҮҮЛ ЧИЙРЭГ, ЭРДЭМ
МЭДЛЭГТЭЙ, ЭЛБЭГ БАЯН БАЙЛГАХ
ӨМНӨГОВЬ НУТГИЙН ХИШИГ-2028

ХӨТӨЛБӨР

ТЭРГҮҮЛЭХ БОДЛОГЫН 5 САЛБАР

X

ХӨГЖИЛ | Хүртээмжтэй есэлт, орлого, дундаж давхарга

И

ИРЭЭДҮЙ | Инноваци, боловсрол, бүтээмж

Ш

ШУДАРГА | Хүний эрх, засаглал, авлига

И

ИТГЭЛ | Эрүүл мэнд, нийгмийн халамж, тэтгэмж

Г

ГОВЬ | Хүрээлэн буй орчин, ус, бэлчээр

ХӨГЖИЛ: ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ, ОРЛОГО, ДУНДАЖ ДАВХАРГА

X

Эдийн засгийн өсөлтийн зорилго, зорилт

Мэдлэгийн эдийн засаг, технологийн дэвшил, ногоон хөгжил болон уул уурхайд түшиглэсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик, палеонтологи, архиелоги, экологи, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлж, тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгоно.

- Зорилт 1.** Иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэн, өрхийн орлогыг өсгөх замаар оролцоотой эдийн засгийг хөгжүүлж, дундаж давхаргыг тэлнэ.
- Зорилт 2.** Мэдлэг, өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэх орчин бүрдүүлж, экспортод гаргахад дэмжлэг үзүүлнэ.
- Зорилт 3.** Өмнөговь аймгийн эдийн засгийг уул уурхайгаас гадна эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, тээвэр логистик боловсрол, шинжлэх ухаан технологи зэрэг олон нийтийн тулгуурт бүтэцтэй болгоно.
- Зорилт 4.** Өмнөговь аймгийн зээлөн, хатуу дэд бүтцийг хөгжүүлэх замаар аймгийн бизнесийн орчинг сайжруулж, өрсөлдөх чадвартай хувийн хэвшлийг бий болгоно.
- Зорилт 5.** Өмнөговь аймгийг Монгол Улсын Говийн бусийн хөгжлийн тулгуур төв, Даланзадгад хотыг улсын дөрөв дэх том хот болгон хөгжүүлнэ.
- Зорилт 6.** Төрийн болон хувийн секторын цахим шилжилтийг түргэтгэх замаар үр өгөөжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

- Эдийн засгаа уул уурхайн салбарын хэт хараат байдлаас гаргах зорилгоор төрөлжүүлж, нүүрс-химиийн болон хөнгөн-хүнсний үйлдвэрлэл, аялал жуулчлал, мэдлэгийн эдийн засгийн салбаруудын өсөлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх, томоохон төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрийг орон нутгийн бонд гаргах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг зарчмаар хэрэгжүүлэх бодлого баримтална.
- Өмнөговь аймгийн иргэдийг ажлын байраар хангах, өрхийн орлого нэмэгдүүлэх зорилгоор “Өсөлтийг Өрх Бүрд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- Малчдын орлогыг нэмэгдүүлэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, улирлын нөлөөнөөс бага хамааралтай зорилготой “Чинээлэг малчин”

5. Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөрийг хөнгөвчлөх, бэлчээрийг усжуулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах, малчдын ундны усыг эрүүл ахуйн стандарт нийцүүлэх, малжуулах чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
6. “Нутгийн үйлдвэрлэгч” хөтөлбөрийг хэрэгжүүлж аймгийн бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийг өрсөлдөх чадвартай болгох, санхүү, хөрөнгө оруулалтын орон нутгийн эх үүсвэртэй болгоно.
7. Даланзадгад сумын үйлдвэр, технологийн паркийн бүтээн байгуулалтыг дуусгаж, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдад хөнгөн хүнс, боловсруулах үйлдвэрийн парк байгуулна.
8. Үйлдвэр, технологийн паркт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийг санхүү, хөрөнгө оруулалт, газар, дэд бүтэц, бизнесийн зөвлөх үйлчилгээний нэгдсэн бодлого, зохицуулалтаар хангана.
9. Газар тариалан эрхлэх сургалтын бааз суурийг өргөжүүлэн Өмнөговь аймгийн хэмжээнд агро-ойн аж ахуйн байгуулах мэргэжлийн боловсон хүчин, техник тоног төхөөрөмжөөр хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
10. Газар тариалан, мал аж ахуй хосолсон эрчимжсэн болон хагас суурин фермерийн загвар аж ахуй байгуулах санаачилгыг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ.
11. Гашуунсухайт, Шивээхүрэнгийн хилийн боомтын хөгжлийг олон улсын түвшинд хүргэнэ. ~~1617044456~~ Бoomtoor орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүн экспортлох боломжийг нээж өгнө.
12. Өмнөговь аймгийн авто тээврийн бодлогыг хэрэгжүүлж Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс суманд худалдааны зангилаа буюу тээвэр ложистикийн төв байгуулна.
13. Таван Толгойн ордыг түшиглэн кокс-химиийн үйлдвэр байгуулах санаачилгыг бодлогоор дэмжинэ.
14. Өмнөговь аймгийн нутагт газрын давхаргын метан хийг хайх, олборлох, үйлдвэрлэх, тээвэрлэх, ашиглах төслийг бодлогоор дэмжинэ.
15. Өмнөговь аймгийн хэмжээнд адал явдалт аялал, эко аялал жуулчлал, тусгай сонирхлын аялал жуулчлал, тойрон аялал, соёл-танин мэдэхүйн аялал жуулчлалыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хөгжүүлнэ.
16. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын “Аялал жуулчлалыг – Бүх нийтэд” уриалгыг хэрэгжүүлж Орон нутгийн иргэдийн аялал жуулчлалаас хүртэх ашиг орлогыг нэмэгдүүлнэ.
17. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг дэмжин хөгжүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын мастер” төлөвлөгөөг хэрэгжүүлж, шинэ үйлчилгээг нэвтрүүлэн иргэд, малчид, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлнэ.
18. Орон нутгийн өвөрмөц онцлогийг харгалзсан эвент арга хэмжээнүүдийг иргэдийн оролцоонд тулгуурлан хөгжүүлж, зохион байгуулалт, үйл ажиллагааг нь орон нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагын хамтын удирдлагын тогтолцоонд шилжүүлнэ.
19. Аялал жуулчлалын гол зорих газруудын бүтээн байгуулалт, үйлчилгээ, үйл ажиллагааг тухайн бүс орон нутгийн иргэд, мэргэжлийн байгууллагын хамтын удирдлагын тогтолцоонд шилжүүлнэ.

20. Зорих газруудад тухайн орчны байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн төв, нийтийн бие засах газар, үзвэр үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, тухайн орон нутгийн брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ажилтнуудын амьдрах байр зэрэг худалдаа үйлчилгээний цогцолборыг бий болгож, зам, цахилгаан, холбооны харилцааны сүлжээгээр хангана.
21. Хэрмэн цав, Ёлын ам, Баянзаг, Шар цав, Ханбогд хайрхны орчим аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, цогцолбор төслүүдийг төр-хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар хэрэгжүүлж, аялагчдыг татах төв болгон хөгжүүлнэ.
22. Ёлын амны хамгаалал, үйлчилгээг шинэ түвшинд гаргаж, Оюутын амнаас Ёлын амны дотоод зогсоол хүртэлх замыг хатуу хучилттай болгож, одоогийн Ёлын музейн орчинд “Ёл иж бүрэн үйлчилгээний цогцолбор”-ыг бий болгож орон нутгийн иргэдэд менежментийн гэрээгээр ашиглуулна.
23. Өмнөговь аймгийн Ханхонгор, Сэврэй сумдыг дайран өнгөрөх хатуу хучилттай автозамын дагуу жуулчид, зорчигчдод зориулсан үйлчилгээний хэсгийн дэд бүтэц, ариун цэврийн байгууламж, зам талбайг байгуулна.
24. Уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн төслийг орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, өрхийн орлого зэргийг бууруулахгүй, тэдний амьдрах орчинд сөрөг нелөөлөл үүсгэхгүй байх бодлого хэрэгжүүлнэ.
25. Уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн төслийн ханган нийлүүлэлтийн сүлжээнд орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийг нэгтгэх, тэдний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
26. Даланзадгад болон бусад боломжит суманд ингэний сүү боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрийг байгуулна. Ингэний сүүг малчдын гараас стандартын дагуу хуриатлуулах хүйтэн хэлхээ барьж байгуулна. Бүтээгдэхүүний борлуулалтыг олон улсад хийхэд дэмжлэг үзүүлнэ.
27. Залуучууд, гарааны бизнес эрхлэгчдийн ажлын байр, санхүү, хөрөнгө оруулалт, технологи, инновацыг дэмжих бодлогын цогц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
28. Говь нутгийн онцлог шингээсэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлж, чөлөөт уран бүтээлчдийг дэмжих замаар соёлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
29. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга, зам тээвэр, хот байгуулалт, инженерийн дэд бүтцийн төслүүдийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, ашиглалтыг оновчтой болгоно. Энэ хүрээнд аймгийн барилга захиалагчийн алба, аймгийн орон сууцны конторыг байгуулна.
30. Өмнөговь аймгийг Монгол Улсын Говийн бүсийн тулгуур хот болгох зорилгын хүрээнд Ханбогд, Гурвантэс, Цогтцээний, Баяндалай, Ханхонгор, Цогт-Овоо сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Төлөвлөлтийн дагуу хот байгуулалтын инженерийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний бүтээн байгуулалтыг хэрэгжүүлнэ.
31. Өмнөговь аймгийн Даланзадгад сумыг Монгол улсын дөрөв дэх том хот болгон хөгжүүлэх, бүтээн байгуулалтын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөлтийн дагуу суурь дэд бүтэц, орон сууц, дулаан, цахилгааны эрчим

32. Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан багийн Цагаанхад, Гурвантэс сумын Морин заг зэрэг суурьшлын бүсийн ундны ус, цэвэрлэх байгууламж, цахилгаан гэх мэт инженерийн дэд бүтэцтэй болгоно.
33. Өмнөговь аймгийн сумдын төвийн гэр хорооллыг иргэдийн оролцоотой дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор “Шинэ хороолол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
34. Өмнөговь аймагт “Шинэ Мянган Айл” орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд зорилтот бүлэг, залуу гэр бүл, төрийн албан хаагч, эмч, багш, хууль хүчний байгууллага, цэргийн хүрээний ажилтан, албан хаагчдыг орон сууцны нөхцөлийг сайжруулна.
35. Аймгийн хэмжээнд орон нутгийн онцлог, байршил, түүхий эдийн давуу байдалд тулгуурлан цемент, шохой, бетон, асфальт зэрэг барилгын материал үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.
36. Өмнөговь аймгийн Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Цогтцэций, Номгон, Ханхонгор болон бусад сумдад эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны хорооллыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.
37. Эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй орон сууц барих, засварлах, халаалт дулааны орчин үеийн технологи нэвтрүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
38. Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс сумдад орон сууц, хаус хороолол байгуулах газарт инженерийн дэд бүтцийг байгуулна. Инженерийн дэд бүтэц бүхий газарт орон сууц, хаус хорооллыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулна.
39. Даланзадгад суманд 50 МВт хүчин чадалтай дулаан, цахилгааны хосолсон үйлдвэрийн станц байгуулж, орон сууц, гэр хорооллыг халаалт, хэрэглээний халуун усаар хангана.
40. Ханбогд, Цогтцэций, Гурвантэс суманд орчин үеийн технологийн шийдэл бүхий хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулна.
41. Даланзадгадаас Сэврэй, Ноён, Гурвантэсийн чиглэлийн хатуу хучилттай автозамыг барьж бүрэн ашиглалтад оруулна.
42. Даланзадгадаас Хүрмэн, Даланзадгадаас Ханхонгор сум чиглэлийн хатуу хучилттай автозамыг ажлыг бүрэн дуусгаж, Даланзадгадаас Номгон чиглэлийн хатуу хучилттай автозамын ажлыг эхлүүлнэ.
43. Тавантолгой-Ханги Мандалын боомтын замаас Манлай сумыг хатуу хучилттай автозамаар холбоно. Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн замаас Баян-Овоо сумыг хатуу хучилттай автозамаар холбоно.
44. Өмнөговь аймгийн Даланзадгад, Булган, Мандал-Овоо чиглэлийн аялал жуулчлалын авто замын ажлыг гүйцэтгэж, Монгол улсын хэвтээ тэнхлэгийн замтай холбох ажлыг эхлүүлнэ.
45. Сэврэй сумын төвөөс Хонгорын гол, Гурвантэс sumaас Хэрмэн цав чиглэлд дотоод, гадаад аялал жуулчлалын зориулалттай хатуу хучилттай автозам барих ажлыг эхлүүлнэ.

46. Төр-хувийн хэвшлийн түншлэлийн Гурвантэс сумын Олон овоотын бүлэг ордоос Гурвантэс сумын төв хүртэл хатуу хучилттай автозамыг барьж ашиглалтад оруулна.
47. Өмнөговь Даланзадгад сумыг аялал жуулчлалын зангилаа хот болгох зорилгоор Гурван сайхан нисэх онгоцны буудлыг олон улсын 4С зэрэглэлийн олон улсын онгоцны буудал болгоно. Олон улс, орон нутгийн нислэгийн тоо, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
48. Ханбогд, Сэргэй, Гурвантэс, Номгон сумдад нисэх онгоц хүлээн авах нисэх буудлыг байгуулж, аялал жуулчлал, иргэний зориулалтын орон нутгийн нислэг үйлддэг болгоно.
49. Өмнөговь аймгийн айл бүр, алслагдсан нутгийн иргэд, төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд бүрэн холбоно.
50. Мэдээлэл харилцаа холбооны шинэ техник, аж үйлдвэрийн IV, Инновацийн 2.0 эрин үеийн технологийн дэвшлийг бүх шатанд хөгжүүлэх зорилготой “Цахим Өмнөговь” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
51. Аймгийн хэмжээнд барилга, тээвэр, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний салбарт цахим шилжилтийг түргэтгэхийг урамшуулах, санхүү, хөрөнгө оруулалтын хөшүүргийг бий болгоно.
52. Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэргэй, Ноён сумдыг.govийн бүсийн эрчим хүчний нэгдсэн систем эсвэл төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд эрчим хүчний дотоодын эх үүсвэрт холбоно.
53. Нар, салхины зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглан, эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангах улмаар экспортыг бодлогоор дэмжинэ.
54. Өмнөговь аймгийн иргэд, аж ахуйн нэгж, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, байгаль орчны төслийг гадаргын усны эх үүсвэртэй холбох зорилгоор Орхон-Онги, Хэрлэн Тоонот төслүүдийг бодлогоор дэмжинэ.
55. Өмнөговь аймгийн сүм, суурин газрын цэвэр ус, бохир ус, дулааны шугамд айл өрхийг холбох ажлыг үе шаттай хэрэгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
56. Төрийн худалдан авалтыг үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний дотоодын болон орон нутгийн зах зээл дэх борлуулалтыг дэмжихэд чиглүүлнэ.
57. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн бизнес эрхлэхтэй холбоотой хяналт, шалгалтыг давхардуулахгүй, төрийн ямар нэгэн дарамт үзүүлэхгүй байх бодлого хэрэгжүүлнэ.

ИРЭЭДҮЙ: БОЛОВСРОЛ, ИННОВАЦ, БҮТЭЭМЖ

И

Боловсролын салбарын зорилго, зорилт

Иргэд, хүүхэд, залуус олон талт боловсролыг хүртээмжтэй олох нөхцөлийг бүрдүүлэн, тэдний гэр бүл, сургуулийн орчинд зөв төлөвшил, хүмүүжил, сурах арга барил эзэмшиүүлэх замаар аль ч орны хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх.

- Зорилт 1.** Цэцэрлэг, сургуулийн хамран сургалтыг зохих түвшинд байлгаж, хүүхэд, залуусын сурах бүтээлч орчин бүрдүүлнэ.
- Зорилт 2.** Багшийн ажиллах, амьдрах орчинг сайжруулах бодлого хэрэгжүүлэх замаар багш, боловсролын салбарт ажиллагчдад мэдлэг ур чадвар, заах аргазүйгээ тасралтгүй хөгжүүлэн ахиулах нөхцөл бий болгоно.
- Зорилт 3.** Жил бүр гадаад, дотоодын щилдэг их сургуульд сурах оюутны тоог нэмэгдүүлэх бодлого баримтална. Тус бодлогын хүрээнд боломжит их сургуультай хамтарсан тэтгэлгийн сан байгуулах бодлого хэрэгжүүлнэ.
- Зорилт 4.** Сурагч, залуус, иргэдийг Өмнөговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, өөрийн дур сонирхолтой мэргэжлээр сурах боломжийг бүрдүүлнэ.
- Зорилт 5.** Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг шинээр байгуулж, шинэ төрлийн мэргэжил эзэмших ангиудыг нээж, хэрэгцээт мэргэжлээр суралцахыг бодлогоор дэмжинэ.
- Зорилт 6.** Бүх насны иргэд байнга сурч боловсрох, шинэ мэргэжил, ур чадвар эзэмших, тасралтгүй өөрийгөө хөгжүүлэх боломжоор хангана.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

Багшийн хөгжил

58. Орон нутгийн харьят, ажиллаж буй багш нарыг гадаадад сурах, мэргэжил дээшлүүлэх боломжоор хангах зорилгоор "Чадварлаг багш" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
59. Орон нутагтаа тогтвортой суурьшилтай, амжилттай ажиллаж байгаа төрийн албан хаагч, иргэдийг гадаад оронд туршлага судлуулах, мэргэшүүлэх "Хөгжлийн гүүр" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
60. Өмнөговийн харьят болон чадварлаг мэргэжилтнүүд аймаг, орон нутагтаа ирж ажиллахыг бодлогоор дэмжин "Эзэмсхэн мэргэжлээрээ эх нутагтаа ажиллая" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

61. Даланзадгад, Цогтцэций, Ханбогд, Гурвантэс суманд хүн амын өсөлтийн хэрэгцээнд тулгуурлан цэцэрлэг, сургуулиудыг шинээр байгуулж, нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 байлгах бодлогын хэрэгжилтийг хангана.

Албан боловсрол, сургуулийн өмнөх боловсрол

62. Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах аргазүйд суралцах, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр мэргэших хүсэлтэй сургуулийн өмнөх болон бага боловсролын багш боловсон хүчнийг дэмжих замаар хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах нөхцөлийг сайжруулна.
63. Суралцахуйн болон оюуны бэрхшээлтэй хүүхдэд тусламж дэмжлэг үзүүлэх сайн дурынханд орон нутгаас урамшуулал олгох тогтолцоо бүрдүүлж, "Туслах багш – Сүүдэр багш" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
64. Цэцэрлэгүүдэд "Зуны цэцэрлэн" хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжиж, зах зээлийн зарчмаар ажиллах чөлөөт боломжийг нээнэ. Ингэснээр асран хамгаалагчид ажил хийх, хүүхэд аюулгүй орчноор хангагдах, багш нар нэмэлт орлого олох боломжтой болно.
65. Сургалтын үйл ажиллагаа явуулдаг иргэн, байгууллага холбогдох хууль дүрмийн хүрээнд стандартад нийцсэн өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхийг бодлогоор дэмжинэ.
66. Цэцэрлэг, сургууль, дотуур байрны хоолны амт, чанарыг сайжруулах, ялангуяа сумдын дотуур байрны гал тогоо, хоол бэлтгэлийн орчин нөхцөлийг сайжруулна.

Ерөнхий боловсрол

67. Дунд, ахлах ангийн сурагчдыг дотоод гадаадын олон улсын сургуулиудад урт болон богино хугацаагаар суралцах боломжийг олгох зорилгоор "Сурагч солилцоо" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
68. Цогт-Овоо, Баян-Овоо, Мандал-Овоо, Хүрмэн, Ноён, Булган, Манлай, Сэврэй, сумын дунд сургуулиудыг хүн амын хөгжлийн хэрэгцээнд нь тулгуурлан өргөтгөж, 12 жилийн сургалттай бүрэн дунд сургууль болгох буюу бааз суурийг бэхжүүлнэ.
69. Элсэлтийн ерөнхий шалгалт болон олон улсын шалгалтын үнэлгээнд өндөр оноо авсан багш, сурагчдыг тэтгэн урамшуулах тогтолцоо бүрдүүлнэ.
70. Сургуулийн номын сангийн үйлчилгээг сайжруулах "Найз номын сан" хөтөлбөр хэрэгжүүлж, номын фондыг баяжуулж, уншлагын танхимын орчин нөхцөл, ялангуяа гэрэлтүүлгийг олон улсын стандартын дагуу тавьж тохижуулан, ном ариутгах төхөөрөмжөөр хангана. Мөн "цахим номын сан" нэвтрүүлэн, ном бүртгэлийг цахимжуулах, номын санчийг чадавхжуулах, ажлын үр дүн, уншигчийн тоогоор алдаршуулах, орон нутгаас урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
71. Бага, дунд ангийн сурагчдыг "Үдийн хоол", ахлах ангийн сурагчдыг "Үдийн цай" хөтөлбөрт хамруулж, идэвхтэй сурх үйл ажиллагааг дэмжин, хоол тэжээлийн

Мэргэжлийн боловсрол

72. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн нарийн мэргэжлийн шинэ ангиудыг нээж, инженер техникийн мэргэжлийн ажилчин бэлтгэнэ.
73. Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад гадаад дотоодын ижил төстэй сургалтын байгууллагад дадлагажих, туршлага солилцох боломжийг олгоно.

Дээд боловсрол

74. Бага ангийн багш, сувилагч зэрэг орон нутагт нэн тулгамдаж буй боловсрол, эрүүл мэндийн салбарын мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн “Цалинтай оюутан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
75. Жил бүр гадаад, дотоодын шилдэг их сургуульд урт богино хугацаагаар суралцах оюутны тоог нэмэгдүүлж, боломжит их дээд сургуультай “Оюутан солилцоо” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн орон нутагтаа “Олон улсын боловсролын яармаг” тогтмол зохион байгуулж, гадаадад суралцах зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээг дэмжинэ.
76. Улаанбаатар дахь ~~Өмнөговь аймгийн~~ оюутны хотхоны үйл ажиллагааг сайжруулж, нутгийн оюутнуудын сурах, амьдрах таатай орчин бүрдүүлнэ.
77. Үндэсний болон олон улсын ~~шалгалт~~ үнэлгээ, уралдаан, тэмцээн, олимпиадад өндөр оноо авсан, амжилт гаргасан багш, оюутныг урамшуулдаг тогтолцоо, хөшүүргийг оновчтой болгоно.
78. ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн баазыг өргөжүүлж, лабораториудыг ~~шардлагатай~~ тоног төхөөрөмжөөр хангаж, сургалтын орчинг сайжруулна.
79. ШУТИС-ийн харьяа Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургууль болон Политехникийн коллежийн нөөцөд тулгуурлан орон нутагт хэрэгцээт зам, барилга, аялал жуулчлалын зэрэг зарим салбарын мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлж, мэргэжлийн ангиудыг нээнэ.
80. Малын эмч, мал зүйч, ойн инженер, агрономич зэрэг мэргэжлээр нас харгалзахгүй суралцахыг бодлогоор дэмжиж, хөдөө аж ахуйн салбарт дутагдаж байгаа хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэнэ.

Албан бус боловсрол

81. Буянт хотхон хүүхдийн зусланг дөрвөн улирлын тасралтгүй үйл ажиллагаатай болгож, гадаадын амрагч хүүхдүүд хүлээн авах бааз суурийг бэхжүүлэн, олон улсын статустай болгоно.
82. Аймаг, сумын төв, хот суурины хүүхдүүдэд зориулсан “Нүүдэлчин” зуслан байгуулахыг орон нутгаас тодорхой санхүүжилтээр дэмжин, хүүхэд багачуудын монгол ахуй соёл, уламжлалт хүнс, мах, сүү цагаан идээ боловсруулах арга

- 83.Хүүхэд, залуус, иргэд, олон нийтэд зориулсан сургалт, судалгаа, солилцоо явуулдаг орон нутагт бүртгэлтэй аливаа боловсролын байгууллага, иргэний санаачилга, ашгийн болон ашгийн бус үйл ажиллагааг дэмжих нээлттэй бодлого хэрэгжүүлнэ.
- 84.Үндэсний болон бусад орон нутгийн онцлогтой спортыг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, сумдын хүн амын өсөлт, хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан спорт заал, спорт талбай, спорт цогцолбор барьж байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах, бүх нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх орчин бүрдүүлнэ.

Шинжлэх ухаан, технологи, инновац

- 85.Бүх салбарын цахим шилжилтийг түргэтгэхийн тулд “Цахим Өмнөговь” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, бүх нийтийн цахим хэрэглээний ур чадвар, цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдал, харилцаа хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.
- 86.Хүүхэд, залууст зориулсан компьютер программчлал, инженерчлэл, математик, мэдээлэл зүй, роботикс, техник загвар, кодингийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага, иргэдийг дэмжих бодлого баримталж, сумдад STEM сургалтын төвүүдийг байгуулна.
- 87.Математик, физик болон байгалийн шинжлэх ухааны багш нарыг STEM боловсролын чиглэлд чадавхжуулах, олон улсын туршлага судлах, сургалтын шинэ аргазүй нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 88.Инновац технологийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шинжлэх ухаан, технологийн салбарын судалгаа, туршилт явуулж буй болон өндөр технологи нутагшуулж буй иргэн, байгууллагын төсөл, санаачилгыг орон нутгаас дэмжинэ.
- 89.Эрдэмтэн, судлаачдын технологийн шийдэл, шинэ бүтээл, оновчтой санааг оюуны өмчийн эрхийн тухай хуулиар баталгаажуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хөгжүүлэх, зах зээлд нэвтрүүлэхэд нь дэмжинэ.
- 90.Бүх насны иргэд алсын зайн төрөл бүрийн сургалтад хамрагдах боломж хангасан нээлттэй сургалтын систем, платформ хөгжүүлж, түгээхийг бодлогоор дэмжинэ.
- 91.Олон улс, бүс нутгийн шинжтэй байгалийн шинжлэх ухааны судалгааны төв байгуулж, судалгааны үр дүнг бүтээлчээр ашиглахыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 92.Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны чиглэлд эрдэмтэн судлаачдыг бэлтгэх, чадавхжуулах, судалгааны ажил хийх сонирхлыг нэмэгдүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.

Соёл, урлаг, спорт

- 93.Аймгийн хэмжээнд номын сангудын хөгжлийг шинэ тувшинд гаргах зорилгоор “Нутгийн номын сан” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Номын санчийг чадваржуулах, ном

бүртгэлийн дэвшилтэт программ ашиглах нөхцөлийг сайжруулах, уншлагын танхимыг тохижуулах, номын фондыг өргөжүүлж, найдвартай интернэт сүлжээгээр хангах, “цахим номын сан” ашиглах боломж нээх, номын сангийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, уншигчийн тоогоо нэмэгдүүлсэн номын санчийг урамшуулах тогтолцоо бий болгоно.

94. Хүүхэд, залуус, иргэдийн урлаг, спорт, гоо зүйн боловсролыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. Даланзадгадад аймгийн “Ботгоон” хүүхдийн театр, “Говь арт” урлан бүтээх төв, хүүхдийн номын сан байгуулна. Цогтцэций, Ханбогд, Номгон суманд хүүхэд залуучуудын хөгжлийн ордон байгуулна.
95. Сангийн далай хийдийн соёлын дурсгалыг сэргээн засварлана. Соёлын өвийг хадгалан хамгаалах бүх нийтийн ойлголт, ухамсрыг дээшлүүлэх, түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
96. Түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтыг олон улсын жишигт хүргэнэ.
97. Соёл урлагийн салбарын мэргэжлийн боловсон хүчиний дутагдлыг арилгах бодлого хэрэгжүүлнэ.
98. Өмнөговь аймгийн ондоошлыг илэрхийлэх Соёлын биет бус долоон ай савын хүрээнд уламжлуулах, хөгжүүлэх, хадгалах хамгаалах, судлах, сурталчлах үйл ажиллагааг дэмжинэ.

Насан туршийн боловсрол


99. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсрол, ёсвер насныхны бэлгийн боловсрол, залуучуудын гэр бүл төлөвлөлтэд чиглэсэн сургалтуудыг дэмжинэ.
100. Бүх нийтийн монгол уламжлал, ёс заншил, байгаль, экологийн боловсролыг дээшлүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.
101. Бүх нийтийн хотын соёл хотын дүрэм, нийгмээр амьдрах зарчим, хоггүй амьдралын хэв маяг гэх мэт суурин соёлын талаарх мэдлэгийг түгээнэ.
102. Бүх нийтийн англи хэлний боловсролын чиглэлд үйл ажиллагаа явуулж буй иргэний санаачилга, байгууллагын гаргасан амжилт, үр дүнд нь суурilan урамшуулдаг тогтолцоог бий болгоно.
103. Бүх нийтийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
104. Бүх нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ. Мөн бүх нийтэд зориулсан төслийн менежментийн сургалт, насанд хүрэгчдэд зориулан нягтлан бодох бүртгэлийн эчнээ сургалт зэргийг орон нутагтаа зохион байгуулахыг бодлогоор дэмжинэ.
105. Малчид, өрхийн үйлдвэрлэл, хувийн бизнес эрхлэгчид, гарцааны аж ахуйн нэгжүүдийг чадавхжуулах, өрсөлдөх чадамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн ур чадварын сургалтуудыг тогтмол явуулах, гадаад дотоодод туршлага судлахад нь дэмжлэг үзүүлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ШУДАРГА: ХҮНИЙ ЭРХ, ЗАСАГЛАЛ, АВЛИГА



Засаглалын хөгжлийн зорилго, зорилт

Хувь хүний халдашгүй байдал, хууль ёсны эрх, ашгаа хамгаалуулах, шударгаар шийдвэрлүүлэх, гэм буруутай нь шүүхээр тогтоогдоогүй байхад ял зэм хүртэхгүй, хуулиас гадуур мөрдөн шалгагдахгүй байх, ялгаварлал, хүчирхийллээс ангид, айdasгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ

- Зорилт 1. Хүний эрхийг дээдэлсэн, иргэдийн оролцоог хангасан, ил тод, ёс зүйтэй, шуурхай төрийн үйлчилгээг оновчтой бодлогоор удирдана.
- Зорилт 2. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, авлига, хүнд сурталгүй, иргэдийн эрэлтийг хангасан үйлчилгээг бий болгоно.
- Зорилт 3. Аймгийн бүх шатны удирдлага иргэдийн оролцоотой шийдвэр гаргадаг, тэр шийдвэр нь ил тод, шуурхай хүртээмжтэйгээр иргэдэд хүргэдэг болно.
- Зорилт 4. Орон нутгийн иргэдийн тэгш оролцоог хангаж, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхах байдлыг устгана.
- Зорилт 5. Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор “Цахим засаглал” бий болгоно. 
 17144456
KH 0068 9047824
- Зорилт 6. Хүний эрх, иргэний оролцоо, өөрийн зохицуулалтын чиглэлд үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, сайн дурын үйл ажиллагааг дэмжинэ.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

106. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах явдлыг эрчимжүүлнэ.
107. Орон нутгийн төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг, соёлын хүрээнд Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендерийн бодлого хэрэгжүүлнэ.
108. Төрийн бүх шатанд хүний эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, байгаль орчны эсрэг аливаа үйл ажиллагааг дэмжихгүй, оролцохгүй байх зарчмыг мөрдүүлнэ.
109. Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагаанд иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулна. ИТХ-ын төлөөлөгчид болон иргэд, сонгогчдын эргэх холбоог нэмэгдүүлнэ.
110. Иргэдийн цахим өргөдөл, гомдол гаргах, шуурхай шийдвэрлүүлэх боломжийг хангасан цахим өргөдлийн нэгдсэн сүлжээ, платформ бий болгоно.
111. Иргэн цахимаар санаачилга гарган, иргэд цахимаар гарын үсэг цуглуулж тодорхой асуудлыг дэвшиүүлсэн тохиолдолд аймаг, сумын ИТХ шууд авч

хэлэлцэх журам тогтооно.

112. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
113. Нутгийн өөрөө удирдах ёс болон төрийн захиргааны байгууллагын гаргасан бодлого, шийдвэрийн үр нөлөөг бодлогын судалгааны хүрээлэнгээр дамжуулан үнэлдэг болгоно.
114. Аймгийн хэмжээнд төрийн зарим чиг үүргийг иргэний нийгэм, мэргэжлийн холбоодод шилжүүлж, тэдгээрийн чадавхыг дээшлүүлэх, зах зээлийн стандарт тогтоох, хянах эрхийг олгоно.
115. Аймгийн хэмжээнд төрийн зарим ажил, үйлчилгээг иргэний нийгмийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлж, төрийн ачаалал, зардлыг хэмнэх бодлого хэрэгжүүлнэ.
116. Ил тод, нээлттэй байдал, иргэдийн оролцоог хангах зорилгоор Цахим засаглал бий болгоно.
117. Цахим орчны эрх зүйн харилцааг боловсронгуй болгох, цахим орчинд хүний нэр төр, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, байгууллага, хувийн мэдээлэл, нууц, өгөгдлийн аюулгүй байдлыг хангана.
118. Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
119. Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ.
120. Иргэний өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлгүйгээр хүлээн авахаас татгалзсан, шийдвэрлэхгүй хугацаа хэтрүүлсэн төрийн албан тушаалтанд тодорхой хариуцлага хүлээлгэдэг болгоно.
121. Хүний эрх, байгаль орчин зэрэг чиглэлийн төрийн бус, сайн дурын байгууллага, өөрийн зохицуулалтын чиглэлд гаргасан аливаа санаачилгыг дэмжинэ.
122. Улс дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх орон нутгийн чадавхыг дээшлүүлж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх албыг байгуулан мэргэшүүлж, гадаад хамтын ажиллагааг сайжруулна.
123. Хүн худалдаалах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаална, ажлын байран дахь бэлгийн дарамтгүй болгоно.
124. Онцгой байдлын албан хаагчдыг олон улсын аврах ажиллагаанд тогтмол оролцуулж, өндөр хөгжилтэй орнуудтай хамтран аврагчдын солилцооны хөтөлбөр хэрэгжүүлнэ.
125. Гамшигт тэсвэртэй орон нутаг хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдийн гамшигийн эсрэг хариу арга хэмжээний мэдлэг, ур чадвар, оролцоог нэмэгдүүлнэ.
126. Орон нутгийн өмчит, өмчийн оролцоо бүхий аж ахуйн нэгжүүдэд сайн засаглалын орчин үеийн менежментийг нэвтрүүлж, цалин, урамшууллын тогтолцоог стандартжуулна.
127. Төрийн албаны чадахуйн (мерит) зарчмыг хадгална.

ИТГЭЛ: ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАЛАМЖ, ТЭТГЭ

И

Эрүүл мэндийн салбарын зорилт, зорилт

Аймгийн хүн бүрийн эрүүл мэндийг хамгаалах, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг оношлох, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягийг урамшуулах замаар дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд оршино

- Зорилт 1.** Хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Зорилт 2.** Эмнэлгүүдийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Бүсийн эмчилгээ, оношилгооны төвийн үйлчилгээг иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлнэ.
- Зорилт 3.** Иргэдийг эрүүл дадал хэвшил, амьдралын идэвхтэй хэв маягт уриалсан бодлого хэрэгжүүлнэ.
- Зорилт 4.** Хөгжлийн бэрхшээлтэй иргэд идэвхтэй сурч, хөдөлмөрлөх, орлогоо нэмэгдүүлж, нийгмийн харилцаанд ороход тэгш, хүртээмжтэй, тогтвортой нөхцөлийг бурдуулнэ.
- Зорилт 5.** Эмч, сувилагч, эрүүл мэндийн салбарын мэргэжилтний тоо, хүрэлцээг нэмэгдүүлнэ. Тэдний амьдрах орчин, нийгмийн хамгааллыг сайжруулна.

ХӨТӨЛБӨР МАГА ХЭМЖЭЭ
КН:А0068 9047624

128. Иргэн бүр эрүүл мэндийн байгууллагаас чанартай, соёлтой үйлчилгээ хүртэхэд чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. Ингэхдээ эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоог нэмэгдүүлэх, эмнэлгүүдийг өргөтгөх болон шинээр эмнэлэг барих бодлого баримтална.
129. Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагдахыг дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ. Эрт илрүүлгийн нэгдсэн төв, оношилгооны иж бүрэн лабораторийг байгуулж, үйл ажиллагааг жигдрюүлнэ.
130. Аймгийн хэмжээнд 18 хүртэлх насын хүүхдүүдийг урьдчилсан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулах зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэн, насын онцлогт нь тохирсон багцыг боловсруулан тогтмол хамруулна.
131. Хүн амын эрүүл чийрэг байхад зориулагдсан спорт заал, бялдаржуулах төвүүдийг нэмэгдүүлнэ.
132. “Эрүүл элэг”, “Эрүүл шүд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хавдрын химийн эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

133. Гадаад дотоодод хийгддэг нарийн мэргэжлийн өндөр үнэ өртөгтэй эмчилгээ оношилгооны орчин үеийн дэвшилтэт техник технологийг эрүүл мэндийн салбарт үргэлжлүүлэн нэвтрүүлнэ.
134. Бөөр, шээс, бэлгийн замын халдварт өвчинтэй тэмцэх зорилтот аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулна. Өсвөр насыхан болон насанд хүрэгчдэд нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн боловсрол олгох цогц нөлөөллийн ажил явуулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, эрт оношуулах, эмчлүүлэх ач холбогдолтой талаар олон нийтэд зөв ойлголт өгөх, нөхөн үржихүйн асуудлаарх олон нийтийн хүний эрхийн мэдрэмжийг дээшлүүлнэ.
135. Хүүхэд залуусын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи болон цахим тоглоом, видео контентод донтох, сэтгэцэд нөлөөлөх бодист мансуурах зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилтот хөтөлбөр хэрэгжүүлнэ. Нойрны дутагдлаас үүссэн мэдрэлийн ядрагаа, сэтгэл түгшилт, сэтгэл гутралаас сэргийлэх, уур бухимдал тайлах идэвхтэй аргуудыг сурч, сэтгэл хөдлөлийн ур чадваруудыг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээ нэвтрүүлнэ.
136. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга, дэд бүтцийг сайжруулна. Оношилгоо, зайн тусlamж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор нэн шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.
137. Сум, сум дундын эмнэлгүүдийн чанар, хүртээмжийг сайжруулж, яаралтай түргэн тусlamжийн "Нисдэг баг" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
138. Нийгмийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан орон нутагт эрүүл зүй, урьдчилсан сэргийлэх лаборатори байгуулна.
139. Аймаг, орон нутгийн хэмжээнд сувилагч мэргэжилтний хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлнэ. Эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд тогтвортой суурьшилтай ажиллахад таатай нөхцөл бүрдүүлэх зорилгоор эдийн засаг, нийгмийн баталгааг сайжруулан, орон сууцжуулах зэрэг хөтөлбөр хэрэгжүүлж, орон нутгаас хөшүүрэг дэмжлэг бий болгоно.
140. Хувийн хөрөнгө оруулалтаар спорт, баялдаржуулах клуб, эрүүл зөв амьдралын хэв маягийг ард иргэдэд хэвшүүлэх зорилго бүхий үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
141. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн төвийг Даланзадгад суманд байгуулна. Тэдний эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
142. Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөрийг боловсронгуй болгож, эх хүүхдийн хоол тэжээлд дэмжлэг үзүүлэх "Сүү тараг" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
143. Эмч мэргэжилтний мэдлэг ур чадвар, ёс зүй хариуцлага, харилцаа хандлагыг сайжруулах сургалт, арга хэмжээ зохион байгуулж, эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлж, харилцаа хандлагыг сайжруулах, дутагдалтай мэргэжилтнээр хангана.
144. Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгооны лабораторийн хүчин чадлыг сайжруулах, Улаанбаатар хот-аймаг-сумдын эмнэлгийн үйлчилгээг телемедицинээр холбож орчин үеийн дэвшилтэт зайны эмчилгээний аргыг БОЭТ-д нэвтрүүлнэ. Аймгийн иргэдэд эрүүл мэндийн зуучлах үйлчилгээг

үзүүлэх, "Өмнөговийн иргэдэд зөвлөн зуучлах төвийг" Улаанбаатар хотод байгуулна.

145. Агаарын бохирдол, тоосжилт, хөрсний бохирдол, хорт ургамлаас шалтгаалсан харшлын өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор "Харшлын эсрэг тэмцье" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
146. Цахим эрүүл мэндийн системийг хөгжүүлж, үйлчилгээний шуурхай байдал, эмнэлгийн үйл ажиллагааны зохион байгуулалт, ажлын чанар, хариуцлагыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
147. Гэр бүл хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хүрээнд хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв болон гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагааг дэмжих, орчин нөхцөлийг сайжруулна.
148. Сум, суурин газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах, амьдрах дэд бүтэц /зам, барилгын гадна, дотно, мэдээллийн гэх мэт/, орчин бий болгоно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настанд зориулсан "Хөгжлийн төв"-ийн үйл ажиллагааг жигдруулнэ.
149. Нийгмийн халамжийн тэтгэмж олгох шалгуурыг сайжруулж, халамж хүртэгсдийг илүү оновчтой тодорхойлох замаар зорилтот хэсэгт хүргэнэ.
150. Зорилтот бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй, орлого багатай иргэдийн амьдрах таатай нөхцөлөөр хангах зорилготой түрээсийн орон сууц хөтөлбөр хэрэгжүүлнэ.
151. Ажилд зуучлах үйлчилгээг эрчимжүүлж, ажилгүйчүүдийг бүртгэх бүртгэлийн нэгдсэн системийг аймгийн хэмжээнд боловсруулна. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах зорилгоор "Өсөлтийг өрх бүрд" хөтөлбөрийг боловсронгуй болгож үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
152. Аймгийн хэмжээнд буй нэн ядуу өрхүүдэд зориулан, өрхийн амьжирагааг дээшлүүлэх бизнес сургалтыг ТББ болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
153. Ахмад настан, 40-өөс дээш настай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлт, хөгжил хамгааллыг сайжруулна.
154. Эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний чанар, хүртээмж, техникийн хангалтыг сайжруулна. СОЛАМЖЕ
A0068 9047824
155. Гэр бүл төлөвлөлт, эрүүл мэнд, эрүүл хооллолт, амьдралын зөв хэвшлийн боловсролыг хангах чиглэлд ажиллаж буй ТББ, иргэдийн өгөөжтэй үйл ажиллагааг дэмжинэ. Залуучуудын эрүүл мэнд боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих зорилгоор Цогцэций, Ханбогд, Гурвантэс сумдад Залуучууд хөгжлийн төвийн барилгыг барьж ашиглалтад оруулна.
156. Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээг дэмжих зорилгоор Цогцэций, Ханбогд, Гурвантэс сумдад Залуучууд хөгжлийн төвийн барилгыг барьж ашиглалтад оруулна.
157. Иргэдийн хүнсний бүтээгдэхүүнээ зөв сонгох, аюулгүй хүнс хэрэглэхийн ач холбогдол болон хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнээс татгалзах зан үйлийг дэмжинэ.
158. Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөнийг аймгийн хэмжээнд өрнүүлж, Хүнсний хангамж-аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүнсний хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

159. Хүн амыг стратегийн эрүүл, аюулгүй хүнсээр хангах ажлын хүрээнд эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан мал нядалгааны газрыг сумдын төвүүдэд байгуулна.
160. Гэр бүл болон иргэд хамтран нийгэмд хорших маягаар хөдөлмөрлөх, өөрийгөө хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
161. Ахмадын амралт сувиллын газар, хоол тэжээлийн төвийг сум бүрд байгуулна. Ахмад настны хөгжил, хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор зарим сумдад ахмадын хөгжлийн өргөө байгуулна.
162. Бүсийн эмчилгээ оношилгооны төвд алсын зайн оношилгоог нэвтрүүлж, цахим оношилгооны чадавхыг нэмэгдүүлж, бичил бүсийн нэгдсэн эмнэлгүүдтэй холбоно.

ГОВЬ: ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН, УС, БЭЛЧЭЭР

Г

Байгаль орчны салбарын зорилго, зорилт

Говь цэлийн бүсийн экологийн тэнцвэрийг хангах, хүрээлэн буй орчны унаган төрхийг хэвээр хадгалан үлдээх, хүний буруутай үйл ажиллагаа, уул уурхайн хайгуул, олборлолт, тээвэрлэлт, үйлдвэрлэлээс байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны хэтийн бодлогын удирдлагыг орон нутгийн түвшинд оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх.

- Зорилт 1.** Иргэдийн оролцоотойгоор орчны бохирдлыг бууруулах аян, төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Зорилт 2.** Агаар болон хөрсний бохирдлыг зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулна.
- Зорилт 3.** Гэр хорооллоос үүдэлтэй орчны бохирдлыг бууруулна. Хуурай технологийн жорпонг байгуулсан санаачилгыг дэмжинэ.
- Зорилт 4.** Байгаль орчинд хохирол учруулсан аливаа хуулийн этгээд, иргэнд зохих хариуцлагыг хүлээлгэж хохирол барагдуулах механизмыг боловсронгуй болгоно.
- Зорилт 5.** Уул уурхайгаас үүдэлтэй байгаль орчны бохирдлуудыг бууруулна. Хууль бус лицензийг цуцалж, эвдэгдээгүй газар нутгийг унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, аялал жуулчлалын шинэ зорих газар бий болгоно.
- Зорилт 6.** Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ.
- Зорилт 7.** Экологийн бүхий л төрөл зүйл, тэр дундаа ховордож буй ан амьтан, ургамлыг хамгаална.
- Зорилт 8.** Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх чиглэлд төр-хувийн хэвшлийн түншлэлийг бодлогоор дэмжинэ.

ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭ

163. Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн хайгуул, олборлох, баяжуулах үйлдвэр, дэд бүтцийн төслөөс байгаль орчин, иргэн аж ахуйн нэгжид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, талуудын харилцан ойлголцол, хамтын ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх зорилгоор аймгийн Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлийг байгуулна.
164. Өмнөговь аймагт иргэд, аж ахуй нэгж, төрийн байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд мод, бут тарих, агро-оин аж ахуйг хөгжүүлэх санаачилгыг дэмжих “Ногоон говь”, “Ногоон алт” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
165. Хавтгай, бөхөн, тахь, хар сүүлт, цасны ирвэс, цагаан зээр, хулан, зэрэг дэлхийд ховордсон амьтдыг хамгаалах, өсгөх замаар тусгаарлагдсан популяцуудыг бий болгоно. Булганы сумын Халzan хайрхан ууланд Говийн гайхамшигт зургаан амьтад Хавтгай, Бөхөнгийн судалгаа, хамгааллын байгалийн паркийг бий болгоно.
166. Экспортын тээврийн хатуу хучилттай автозам, төмөр зам зэрэг шугаман дэд бүтцэд зэрлэг амьтдын дамжин өнгөрөх гарц, гармыг төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барьж байгуулах.
167. Зэрлэг амьтны усны эх үүсвэрийг нэмэгдүүлж, бага гүний худаг гаргах, дарагдсан булаг, худгийг сэргээнэ.
168. Олон улсын Говь судлалын төвийг байгуулах эрх зүй, газар нутгийн боломжийг бий болгож,.govийн байгаль цаг уур, биологийн олон янз байдлыг судлах хамгаалах, олон талт хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.
169. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг сайжруулахад олон улсын ба мэргэжлийн байгууллага, орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ. Ийм газрын тодорхой хэсгийг нутгийн иргэдийн бүлэг, нөхөрлөлд менежментийн гэрээгээр ашиглуулах бодлого хэрэгжүүлнэ.
170. Зэрлэг амьтан судлах хамгаалах тусгай сонирхлын аяллыг хөгжүүлэх зорилгоор алслагдсан, .govь цөлийн бүс газар нутгуудад зэрлэг амьтад, нүүдлийн зүйлүүдэд зориулсан усалгааны цэг, хөв цөөрмийг байгуулж, Экологийн коридор – Холбоос нутгийг байгуулна.
171. Орон нутгийн иргэдийн Байгаль хамгаалах нөхөрлөл, ТББ-ыг дэмжиж байгаль хамгааллын үр шимийг хүртэх боломжийг бий болгоно.
172. “Хашаандаа сайхан амьдарцаа” аяныг өрнүүлж иргэдийг хашаандаа ая тухтай сайхан амьдрах дэд бүтцээр хангана. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн ашигт ургамал, жимс жимсгэнэ, алим тариалалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
173. Хариуцлагатай уул уурхайн нэр бүхий найман зарчмыг Байгаль орчныг хамгаалан тэтгэх түншлэлээр дамжуулан хэрэгжүүлнэ.
174. Агаарын бохирдол, хөрсний бохирдол, экологийн хүчин зүйлийн зэрэг байгаль орчны үзүүлэлтүүдийг тогтмол хэмжиж, үр дүнг дүгнэж байна.
175. Уул уурхайн үйлдвэрлэл хөгжиж буй сум, аймагт тоосжилтыг бууруулах, агаарын бохирдлыг арилгах “Бохирдолгүй Өмнөговь” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
176. Уул уурхай, аж үйлдвэр, дэд бүтцийн төслүүдийн төв оффисыг Өмнөговь

аймагт байгуулж, орон нутгийн иргэд, байгаль орчинд тулгарч буй асуудлыг хамтран шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

177. Байгалд ээлтэй, ногоон технологийн шийдэл, санхүүжилтийн хувилбарыг сурталчлан таниулах, мэдээллээр хангах, судалгаа шинжилгээ хийх зориулалт бүхий Технологи дамжуулалтын төв байгуулна. Байгаль орчинд халгүй технологи нэвтрүүлэх хувийн хэвшлүүдийг санхүү, хөрөнгө оруулалт, бодлогоор дэмжинэ.
178. Задгай булаг шанд, баян бүрд, горхи, гадаргад ойрхон уст цэгүүдийг дайруулан ногоон бүс байгуулах иргэд, аж ахуйн нэгжийн санал санаачилгыг дэмжинэ.
179. Гар аргаар алт болон бусад түүхий эд олборлогчдыг бичил уурхайн нэгдсэн зохион байгуулалтад орж ажиллах санаачилгыг дэмжиж, эрх зүйн орчныг бүрдүүлэн ажиллана.
180. Аймгийн ба сумын тусгай хамгаалалттай газрыг шат дараалан өргөтгөнө. Зэрлэг амьтдын дамжин өнгөрөх, нүүдэллэх коридор нутгийг орон нутгийн болон Улсын тусгай хамгаалалтад авах бодлогыг хэрэгжүүлнэ.
181. Говийн бүсийн экосистемд нөлөө үзүүлэх шүхэр зүйлийг хамгаалах, өсгөхөд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, зэрлэг амьтан судалж, өсгөн үржүүлэх чиглэлд дотоод, гадаадын мэргэжлийн болон олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
182. Аймгийн усны нөөц, чанарын, хяналтын нэгжийн үйл ажиллагааг бэхжүүлж, газар нутгийн усны судалгаа, шинжилгээ, ашиглалт, хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгоно.
183. Аймгийн иргэд, аж ахуйн нэгж, уул уурхай, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн төслийн усан хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгоход чиглэсэн “Орхон-Онги”, “Хэрлэн-Тоонот” төслүүдийг бодлогоор дэмжинэ.
184. Аймгийн хэмжээнд төв суурин газар, газар тариалан, ногоон байгууламж, таримал ойн сангийн усны эх үүсвэрт зориулан хөв цөөрөм, гадаргын усаар гүний усыг арвижуулах төсөл, газрын доорх далан байгуулах төслүүдийг хэрэгжүүлнэ.
185. Төв суурин газар, ногоон байгууламжийг усан хангамжийн нэгдсэн судалгаа хийж, шаардлагатай эх үүсвэрийг шинээр байгуулж, ус хангамжийн нэгдсэн, найдвартай эх үүсвэрт холбоно.
186. Аймгийн хэмжээнд төв суурин газар, малчдыг стандартад нийцсэн цэвэр ундны усаар хангах ажлыг үе шаттай зохион байгуулна. Даланзадгад сумын орон сууцны хэрэглэгчдийн ундны усны аюулгүй байдлыг хангах үүднээс зарим байр, орон сууцны цэвэр усны хоолойг зэс хоолойгоор солино.
187. Аймгийн хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийн газар тариалан, ногоон байгууламжийн усалгаанд усны хэмнэлттэй технологи нэвтрүүлэх санаачилгыг дэмжих, урамшуулах бодлого хэрэгжүүлнэ.
188. Аймгийн хэмжээнд саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх, шинэ технологийг нутагшуулах, саарал усны үйлдвэр болон ус дамжуулах хоолой байгуулж, ногоон байгууламж, үйлдвэр, үйлчилгээнд усны хэрэглээнд ашиглана.
189. Гал, үерийн аюул, газар хөдлөлт зэрэг байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, менежментийг сайжруулна. Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсэд 1-р зэрэглэлийн гал унтраах ангийг

байгуулна.

190. “Модон жорлонгүй анхны аймаг” болох зорилтыг үе шаттай хэрэгжүүлнэ. Хуурай технологийн жорлонг байгуулах санаачилга хэрэгжүүлнэ.
191. Аймгийн хэмжээнд ундны усны мэдээллийн санг боловсронгуй болгож аймгийн усны нэгдсэн мэдээллийн сан байгуулж хүн амын 50-аас дээш хувийг эрүүл ахуйн шаардлага хангасан шинжилгээ бүхий ундны усаар хангах бодлого баримтална.
192. Хүрээлэн буй орчныг хамгаалах, байгальд ээлтэй шинэ технологи, үйлдвэрлэлийг бий болгож үр ашигтай ажлыг түүштэй дэмжин ажиллана.
193. Химийн хорт болон цацраг идэвхт бодис алдагдах, хүн, мал, амьтны гаралтай гоц халдварт өвчин гарахад авах арга хэмжээг оновчтой боловсруулна.
194. Өмнөговь аймгийн экосистем, зэрлэг байгалийн танин мэдэхүйн сурах бичиг, хичээлийн хөтөлбөр бий болгоно. Байгаль хамгаалах сайн дурын клуб, хүүхдийн клуб, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.
195. Байгалийн шинжлэлийн хичээлийн багш нарын сургалтын хөтөлбөрт байгаль орчны бодлогын хөтөлбөр суулгаж, Өмнөговь аймгийн есөн гайхамшигийн аялал, сурагчдын байгаль орчны танин мэдэхүйн календарчилсан сургалт, аяллыг зохиож хэвшинэ.
196. Говь цөлийн экосистем, биологийн олон янз байдал, экосистемд үзүүлдэг хүний буруутай үйлдлийг залуучууд, иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлнэ.
197. Агаар, хөрсний бохирдлыг бууруулах бодлогын хүрээнд Даланзадгад сумын дулааны цахилгаан станцын янданц цахилгаан шүүлтүүр суурилуулна.
198. Айл өрх, аж ахуйн нэгжийн сэргээгдэх орчим хүчийг ашиглах дадал, сонирхлыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
199. Байгаль орчны эсрэг гэмт хэргийг бууруул хамтарсан багийн үйл ажиллагаа тогтвортой болгоно. Биологийн төрөл зүйлийг хамгаалах төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.